

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ ГУЧИНДОЛДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны арванхоёрдугаар сарын 24-ний 11 цаг 05 минутад эхэлж, 11 цаг 33 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, 28 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Өмнөговь, Өвөрхангай, Хэнтий, Увс аймгийн нутгийн захиргааны байгууллагын болон Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх мэргэшлийн шалгалтын дүн	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2015 оны 12 дугаар сарын 10-16-ны өдрүүдэд Өмнөговь, Өвөрхангай, Хэнтий, Увс аймагт тус тус зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Өмнөговь, Өвөрхангай, Хэнтий, Увс аймагт 2015 оны 12 дугаар сарын 10-16-ны өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1, 2, 3, 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 126 иргэн /Өмнөговь аймагт 68, Өвөрхангай аймагт 25, Хэнтий аймагт 20, Увс аймагт 13/-ийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 5, 6, 7 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 57 иргэн /Өмнөговь аймагт 4, Өвөрхангай аймагт 32, Хэнтий аймагт 21/-ийг “Туслах түшмэлийн ангиллын</p>

төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д тус тус бүртгэх

2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан "Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 8, 9, 10, 11 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 35 иргэн /Өмнөговь аймагт 11, Өвөрхангай аймагт 8, Хэнтий аймагт 11, Увс аймагт 5/-ийг, "Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 12, 13, 14 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 23 иргэн /Өмнөговь аймагт 4, Өвөрхангай аймагт 11, Хэнтий аймагт 8/-ийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх

3. Энэхүү тогтоолын 8-14 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 58 нэр дэвшүүлсэн иргэнийг "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Өмнөговь аймаг дахь салбар зөвлөл /Б.Түвшинбаяр/-д, Төрийн албаны зөвлөлийн Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөл /Ц.Ганболд/-д, Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөл /М.Болд/-д, Төрийн албаны зөвлөлийн Увс аймаг дахь салбар зөвлөл /Г.Болор-Эрдэнэ/-д тус тус үүрэг болгох

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах. тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2015 оны 12 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 24 -ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :

1. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 2 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэх

2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 2 дугаар хавсралтад дурдсан 1 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх

3. Нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилохыг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дарга А.Хүрэлшагайд үүрэг болгох

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг

		Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
2	Говьсүмбэр аймгийн ИТХ-ын даргаар ажиллаж байсан Д.Баянжаргалыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргаар 2013-2015 оны хооронд сонгогдон ажиллаж байсан Дагвадоржийн Баянжаргалыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	"Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдэг олгох тухай	<p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам"-ын 3.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны чиг үүрэг, албан үүргээ үнэнч шударга, идэвх санаачлагатай, үр бүтээлтэй гүйцэтгэж, тогтвортой амжилт гарган төрийн албаны үйл хэрэгт бодитой хувь нэмэр оруулсан дараах нэр бүхий 20 төрийн албан хаагчдыг Монгол Улсын "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнах</p> <p>2. Шагнагдсан хүн тус бүрийн тэмдгийг дагалдах мөнгөн шагнал (хоёр зуун мянган төгрөг)-ыг Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам"-ын</p>

		<p>4.2-т заасны дагуу шагнагдагсдад тухайн байгууллагаас олгох</p> <p>3. Шагнагдсан нийт төрийн албан хаагчдад баяр хүргэж, ажлын амжилт хүсэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авсан арга хэмжээ, ахиц дэвшил, үр дүн" сэдвээр Төрийн албаны зөвлөлийн Барилга хот, байгуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн сонсгол сонсож хэлэлцэх</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн Барилга хот, байгуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн сонсгол сонсож хэлэлцэх асуудлыг хойшлуулахаар шийдвэрлэв.</p>

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА